



АРХИВЫН ЕРӨНХИЙ ГАЗРЫН  
ДАРГЫН ТУШААЛ

2019 оны 03 сарын 01 өдөр

Дугаар 6/20

Улаанбаатар хот

Ж.Хажидсүрэнд сахилгын шийтгэл  
ногдуулах тухай

Хөдөлмөрийн тухай хуулийн 131.1.1, Захиргааны ерөнхий хуулийн 26.1, Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8.3.5, Архивын ерөнхий газрын хөдөлмөрийн дотоод журмын 13.1, Жамъяангаравын Хажидсүрэнтэй 2019 оны 02 сарын 27-ны өдөр хийсэн сонсох ажиллагааны тэмдэглэлийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Архивын ерөнхий газрын Захиргааны удирдлагын газрын бичиг хэргийн эрхлэгч Ж.Хажидсүрэн нь Архивын ерөнхий газрын даргын 2015 оны А/68 дугаар тушаалаар баталсан "Албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагаанд мөрдөх журам"-ын 2.3.11, Хөдөлмөрийн дотоод журмын 6.2.4, 6.3.2, 6.3.4, 6.3.5, Хөдөлмөрийн гэрээний 5.1.1, 5.1.5-д заасныг тус тус зөрчиж, удирдлагын зөвшөөрөлгүйгээр байгууллагын архиваас баримт хуулбарлан бусдад олгосон болох нь Байгууллагын архивын 2018, 2019 оны баримт ашиглалтын үйл ажиллагаанд хийсэн дотоод хяналт шалгалтаар нотлогдон тогтоогдож байх тул түүнд сануулах сахилгын шийтгэл ногдуулсугай.

2. Өдөр тутмын үйл ажиллагаандаа холбогдох хууль тогтоомж, дүрэм журмыг чанд мөрдөж, үүрэгт ажилдаа хариуцлагатай хандахыг Ж.Хажидсүрэнд үүрэг болгосугай.

3. Дээрх зөрчлийг гаргахгүй байхыг нийт албан хаагчдад анхааруулж, тушаалын хэрэгжилтийг хангаж ажиллахыг Захиргааны удирдлагын газар /Л.Уянга/-т үүрэг болгосугай.

4. Сахилгын шийтгэл ногдуулсан шийдвэрийг ажилтан үндэслэлгүй гэж үзвэл энэ тухай гомдлоо энэхүү шийдвэрийг мэдэгдсэнээс хойш 30 хоногийн дотор Төрийн албаны зөвлөлд, эсхүл шүүхэд гаргаж болохыг дурдсугай.



С.ЭНХБААТАР

368110158